

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/197/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsdul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/207

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИХ-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БОЛОРТУЯА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих дүнг 328,683.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 23,210.0 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно

Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 91.4 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	495,343,306.91	333,551,546.23
МӨНГӨН ХӨРӨНГӨ	254,952,434.52	42,388,957.78
Банкинд байгаа бэлэн мөнгө	254,952,434.52	42,388,957.78
Төгрөг	254,952,434.52	42,388,957.78
Төрийн сангийн харилцах	254,952,434.52	42,388,957.78
АВЛАГА	00.00	3,935,706.30
Бусад авлага	00.00	3,935,706.30
Байгууллагаас авах авлага	00.00	3,935,706.30
БАРАА МАТЕРИАЛ	240,390,872.39	287,226,882.15
Түүхий эд материал	2,634,600.00	2,634,600.00
Эм боох материал	2,634,600.00	2,634,600.00
Хангамжийн материал	222,461,272.39	267,832,282.15
Бичиг хэргийн материал	6,137,200.00	5,869,800.00
Аж ахуйн материал	48,584,164.75	59,271,722.75
Түлш, шатах тослох материал	00.00	4,000,000.00
Хүнсний материал	53,686,360.00	82,241,088.50
Бусад хангамжийн материал	114,053,547.64	116,449,670.90
Мал амьтад	15,295,000.00	16,760,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,016,593,003.86	6,077,859,284.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,016,593,003.86	6,077,859,284.00
Биет хөрөнгө	5,953,144,170.69	6,015,358,284.00
Барилга, байгууламж, орон сууц	5,631,208,377.00	5,631,208,377.00
Хуримтлагдсан элэгдэл	-458,390,630.05	-593,932,234.81
Авто-тээврийн хэрэгсэл	00.00	229,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,272,222.22
Машин тоног төхөөрөмж (компьютер)	840,400,000.46	887,241,245.46
Хуримтлагдсан элэгдэл	-323,376,828.37	-411,385,895.71
Тавилга, аж ахуйн эд хогшил	292,306,867.67	334,078,178.67
Хуримтлагдсан элэгдэл	-109,203,575.84	-137,644,124.13
Бусад үндсэн хөрөнгө	68,405,000.00	73,405,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-14,040,000.32	-21,175,000.40
Ном	25,834,960.14	25,834,960.14
Биет бус хөрөнгө	63,448,833.17	62,501,000.00
Програм хангамж	6,325,000.00	6,325,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-4,222,166.83	-5,170,000.00
Бусад биет бус хөрөнгө	61,346,000.00	61,346,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,511,936,310.77	6,411,410,830.23
НИЙТ ӨР ТӨЛБӨР	146,282,718.60	142,457,375.79
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	146,282,718.60	142,457,375.79

Өглөг	146,282,718.60	142,457,375.79
Бараа үйлчилгээний зардлын өглөг	34,275,976.60	96,082,988.78
Бусад өглөг	112,006,742.00	46,374,387.01
Байгууллагад төлөх өглөг	112,006,742.00	46,374,387.01
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,365,653,592.17	6,268,953,454.44
Засгийн газрын хувь оролцоо	6,365,653,592.17	6,268,953,454.44
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	723,665,838.00	723,665,838.00
Өмч: - төрийн	723,665,838.00	723,665,838.00
Хуримтлагдсан үр дүн	5,094,282,899.57	4,997,582,761.84
Өмнөх үеийн үр дүн	5,094,282,899.57	5,094,282,899.57
Тайлант үеийн үр дүн	00.00	-96,700,137.73
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,704,854.60	547,704,854.60
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,511,936,310.77	6,411,410,830.23

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,977,135,983.35	4,541,212,979.26
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	320,686,083.35	324,466,979.26
120	Нийтлэг татварын бус орлого	320,686,083.35	324,466,979.26
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,098,800.00	42,086,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,098,800.00	42,086,600.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	307,224,244.70	277,889,556.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	11,363,038.65	4,490,823.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,656,449,900.00	4,216,746,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,239,218,300.00	3,799,526,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,239,218,300.00	3,799,526,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	417,231,600.00	417,219,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	417,231,600.00	417,219,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,715,586,990.71	4,637,913,116.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,715,586,990.71	4,637,913,116.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,610,929,630.71	4,494,540,246.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,306,981,787.82	3,047,601,858.24
210101	Үндсэн цалин	1,403,690,302.82	1,764,706,511.24
210102	Нэмэгдэл	779,856,335.00	1,014,579,216.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	90,597,887.00
210104	Урамшуулал	123,435,150.00	177,718,244.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,673,200.00	379,114,443.70

210201	Тэтгэврийн даатгал	206,497,800.00	256,538,183.70
210202	Тэтгэмжийн даатгал	24,293,900.00	30,644,140.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,146,900.00	15,322,170.00
210204	Ажилгүйдлийн даатгал	12,146,900.00	15,322,170.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,587,700.00	61,287,780.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	429,389,076.60	449,354,004.48
210301	Гэрэл, цахилгаан	19,919,978.60	32,457,336.47
210302	Түлш, халаалт	404,469,098.00	411,331,584.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	5,565,084.01
2104	Хангамж, бараа материалын зардал	75,093,900.20	55,005,122.70
210401	Бичиг хэрэг	27,000,075.00	21,976,870.00
210402	Тээвэр, шатахуун	21,052,170.00	20,267,652.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,721,350.00	12,760,600.00
2105	Нормативт зардал	159,225,762.00	200,009,840.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	405,212.00	762,000.00
210502	Хоол, хүнс	158,820,550.00	199,247,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,848,100.00	28,923,400.00
210604	Урсгал засвар	22,848,100.00	28,923,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,154,533.98	73,185,302.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,258,520.00	33,014,530.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	1,411,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	134,355.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	33,484,813.98	38,625,217.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	254,563,270.11	261,346,275.86
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	230,212,470.11	261,346,275.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,657,360.00	143,372,870.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,657,360.00	143,372,870.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,037,860.00	104,831,270.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,619,500.00	38,541,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	261,548,992.64	-96,700,137.73
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	261,548,992.64	-96,700,137.73

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,665,838.00	547,704,854.60	5,094,282,899.57	6,365,653,592.17

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	723,665,838.00	547,704,854.60	5,094,282,899.57	6,365,653,592.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-96,700,137.73	-96,700,137.73
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	723,665,838.00	547,704,854.60	4,997,582,761.84	6,268,953,454.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,658,548,700.00	4,258,832,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,098,800.00	42,086,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,098,800.00	42,086,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,098,800.00	42,086,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,098,800.00	42,086,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,656,449,900.00	4,216,746,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,239,218,300.00	3,799,526,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,239,218,300.00	3,799,526,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	417,231,600.00	417,219,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	417,231,600.00	417,219,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,542,544,181.80	4,426,673,076.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,542,544,181.80	4,426,673,076.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,414,564,661.80	4,259,887,276.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,306,981,787.82	3,047,601,858.24
210101	Үндсэн цалин	1,403,690,302.82	1,764,706,511.24
210102	Нэмэгдэл	779,856,335.00	1,014,579,216.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	90,597,887.00
210104	Урамшуулал	123,435,150.00	177,718,244.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,673,200.00	383,050,150.00
210201	Тэтгэврийн даатгал	206,497,800.00	260,473,890.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,293,900.00	30,644,140.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,146,900.00	15,322,170.00

210204	Ажилгүйдлийн даатгал	12,146,900.00	15,322,170.00
210205	Эрүүл мэндийн даатгал	48,587,700.00	61,287,780.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	407,231,600.00	391,961,400.00
210301	Гэрэл, цахилгаан	18,000,000.00	25,000,000.00
210302	Түлш, халаалт	384,231,600.00	357,961,400.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	9,000,000.00
2105	Нормативт зардал	153,799,740.00	200,797,938.50
210502	Хоол, хүнс	153,799,740.00	200,797,938.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	25,257,900.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	25,257,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,547,613.98	53,213,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,087,100.00	8,802,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,460,513.98	44,411,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,330,720.00	158,004,630.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,411,020.00	140,429,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,919,700.00	17,574,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,979,520.00	166,785,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	127,979,520.00	166,785,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,360,020.00	128,244,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,619,500.00	38,541,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>116,004,518.20</u>	<u>-167,840,476.74</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	44,723,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	44,723,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	44,723,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	44,723,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>-44,723,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	116,004,518.20	-212,563,476.74
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	138,947,916.32	254,952,434.52
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	254,952,434.52	42,388,957.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. Улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас, санхүүжилтийн орлого	4,587,515,200.00	4,258,832,600.00	328,682,600.00	92.8
Улсын төсвөөс	4,128,210,500.00	3,799,526,700.00	328,683,800.00	92.0
Орон нутгийн төсвөөс	417,219,300.00	417,219,300.00	-	100.0
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	42,085,400.00	42,086,600.00	(1,200.00)	100.0
Туслах үйл ажиллагааны орлого	0.00	0.00	0	0.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,587,515,200.00	4,258,832,600.00	328,682,600.00	92.8
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,587,515,200.00	4,471,396,076.74	116,119,123.26	97.5
Ажиллагчидтай холбогдсон зардал				0.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,132,071,100.00	3,047,601,858.24	84,469,241.76	97.3
Цалин	1,902,135,300.00	1,764,706,511.24	137,428,788.76	92.8
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1229935800	1282895347	-52959547	104.3
Нийгмийн хамгааллын шимтгэл	391,508,700.00	383,050,150.00	8,458,550.00	97.8
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	328,867,300.00	321,762,370.00	7,104,930.00	97.8
Эрүүл мэндийн даатгалын хураамж	62,641,400.00	61,287,780.00	1,353,620.00	97.8
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	671,974,000.00	648,782,668.50	23,191,331.50	96.5
Тогтмол зардал	391,961,400.00	391,961,400.00	-	100.0
Гэрэл цахилгааны зардал	25,000,000.00	25,000,000.00	0.00	100.0
Түлш, халаалтын зардал	357,961,400.00	357,961,400.00	0.00	100.0
Цэвэр, бохир усны зардал	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.0
Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал	671,974,000.00	648,782,668.50	23,191,331.50	96.5
Хоол	213,341,100.00	200,797,938.50	12,543,161.50	94.1
Бусад бараа үйлчилгээний зардал	187,651,100.00	185,152,730.00	2,498,370.00	98.7
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	16,280,700.00	17,574,900.00	(1,294,200.00)	107.9

Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	135,458,500.00	128,244,200.00	7,214,300.00	94.7
Урсгал засварын зардал	25,257,900.00	25,257,900.00	0	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,805,400.00	8,802,300.00	3,100.00	100.0
Мэдээллийн технологийн зардал	46,637,700.00	44,411,100.00	2,226,600.00	95.2
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	38,541,600.00	38,541,600.00	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		254,952,434.52		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		42,388,957.78		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,297,432.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,297,432.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

Байгууллагын дансанд бүртгэлтэй 16,760.0 мянган төгрөгийн өртөгтэй малыг зах зээлийн үнээр үнэлээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 8.3-д "Бараа материалыг УСНББОУС 12 "Бараа материал"-ын дагуу бүртгэнэ" гэснийг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын дансанд бүртгэлтэй малыг зах зээлийн үнээр үнэлэн, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр гаргуулан бүртгэлд тусгах;

2.Илрүүлэлт:

Эд хариуцагч 56,462.4 мянган төгрөгийн үдийн хоолны, 98,248.3 мянган төгрөгийн дотуур байрны хүнсний материалын тайланг цаг хугацаанд нь гаргаагүй, 5 сараар хоцроон бөөн дүнгээр нь тайлагнасан,нягтлан бодогч нь бараа материалын тайланг шалгаж тооцоо бодоогүй байна. Энэ нь тус сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөөгүй, “тасалбар болголт” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

Эд хариуцагчид бараа материалын тайланг тус сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд үнэн зөв гаргах, нягтлан бодогчид эд хариуцагчийн гаргасан бараа материалын тайланг шалгаж, тооцоо бодсон баримт үйлдэж хэвших үүргүүдийг хүргүүлэн биелэлтийг тооцох

3.Илрүүлэлт:

Үр дүнгийн тайланд 6450.0 мянган төгрөгийн түлш халаалтын болон тээвэр шатахууны зардлыг эдийн засгийн ангиллаар нь зөв тайлагнаагүй нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай журам”-ыг зөрчсөн, “ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй байна

Өгсөн зөвлөмж:

Үр дүнгийн тайлангийн зардлуудыг эдийн засгийн ангиллаар зөв бүртгэж хэвших;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

4.Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналтын нэгж нь төлөвлөсөн 18 ажлаас 5 ажлыг бүрэн хэрэгжүүлсэн, хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгасан эсэхийг тайлагнаагүй нь Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3.7.3, 3.7.8 зэрэг заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналтын нэгжид төлөвлөсөн хяналт шалгалтыг бүрэн хийх, хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх, дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхыг дээшлүүлэх үүргүүдийг өгч биелэлтийг тооцох;

5.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 203,579.0 мянган төгрөгөөр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 586,025.3 мянган төгрөгөөр, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 38,025.9 мянган төгрөгөөр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор 291,881.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.5, 6.4.9--д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны тайлан, аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж, баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/		
		Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж

**Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
малыг зах зээлийн үнээр үнэлээгүй байна.	1	16,760.0					1	16,760.0
Эд хариуцагч 56.4 сая төгрөгийн үдийн хоолны хүнсний материалын тайланг цаг хугацаанд нь гаргаагүй, 5 сараар хоцроон бөөн дүнгээр нь тайлагнасан.	1	56,462.4					1	56,462.4
Эд хариуцагч 98.2 сая төгрөгийн дотуур байрны хүнсний материалын тайланг цаг хугацаанд нь гаргадаггүй, 5 сараар хоцроон бөөн дүнгээр нь тайлагнасан	1	98,248.3					1	98,248.3
Үр дүнгийн тайланд түлш халаалтын болон тээвэр шатахууны зардлыг 6.5 сая төгрөгөөр буруу тайлагнасан	1	6,450.0					1	6,450.0
Дүн	4	177,920.7					4	177,920.7

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил илэрсэн.								
Байгууллагын дотоод хяналтын нэгж нь төлөвлөсөн 18 ажлаас 5 ажлыг бүрэн хэрэгжүүлсэн, хяналтаар илэрсэн алдаа зөрчлийг арилгасан эсэхийг тайлагнаагүй байна.	1	0.0					1	0.0
Шилэн дансанд мэдээллийн мөнгөн дүнг үнэн зөв байршуулаагүй	1	1,119,511.7					1	1,119,511.7
Дүн	2	1,119,511.7					2	1,119,511.7